

ХОВД ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭ ТӨВИЙН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

2018.11.19

Ховд дахь БОЭТ нь гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхээр дараахь улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

1. Хамтран ажиллах гэрээгээр зохион байгуулагдсан үйл ажиллагаа

АНУ-ын Virtue Foundation-ний нүдний төрөлжсөн нарийн мэргэжлийн мэс заслын эмч нарын баг 2012-2017 онуудад баруун бүс нутгийн ард иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, шинжилгээ, нүдний болор суулгах, нүдний даралт буулгах, зовхины хагалгаа, латофтальмия, нулимсны суваг үрэвсэх, хялар засах, нүдний протез суулгах, нөхөн сэргээх, мэнгэ ургацаг авах зэрэг мэс заслыг хийдэг бөгөөд эмч нарын бүрэлдэхүүнд нэр хүнд бүхий их сургуулийн доктор, зөвлөх эмч нар Dr. Charles Cole /Чарлес Акерсон Коле/- Нью Йорк хот дахь Колумбия Их Сургуулийн АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, Dr. Tamiesha Frempong /Тамиеша Фремпон/ нь хүүхдийн нүд судлал – солир харааны төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, Преети Харимохан Каушик /Preeti Harimohan Kaushik/ Анагаах Ухаан –Нүдний Мэс Заслын эмч, Мумбайн их эмч, мэс засалчдын коллежийн ХҮНДЭТ ПРОФЕССОР, ЖАНАК МАХАНДРА ШАХ /Janak Mahandra Shah/ нь Set Гордандас Сүндерас Анагаах Ухааны Коллеж [Seth Gordhandas Sunderdas Medical College] хүндэт профессор, нүдний мэс заслын эмч, болон Ziv Sherzer /Зив Щерзе/, Anna Szczepanek /Анна Щзепаник/, Erlinda Lachica /Ерланда лачика/, Karine Hu /Карина Ну/, Raman Parkash, Tanya Khan /Таня хан/ нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж, бүсийн харьяа аймгуудын нүдний мэргэжлийн эмч, сэхээн амьдруулах эмч, нүдний мэргэжлийн сувилагчид болон тус төвийн эмч сувилагчид хамтран ажилласан. Ажиллах хугацаанд 698 хүн үзэж 143 хагалгааг хийгээд байна Мөн энэ хугацаанд баруун бүсийн аймгуудын нүдний нарийн мэргэжлийн эмч, сувлагч нарт ажлын байрны сургалтуудыг удаа дараах зохион байгуулж, дагалдуулан сургалаа.

2. Канад Сангийн Орон нутгийн Санаачилга (КСОНС) Хөтөлбөрийн санхүүжилтаар “Ховд аймгийн боэт-ийн хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” төслийн хүрээнд Хүүхдийн тасгийн эрчимт эмчилгээний өрөөнд 38 сая төгрөгийн санхүүжилтаар амьсгалын аппарат, нярай дулаахан ширээ, өвчтөний хяналтын монитор, биллиметр, пульсохиметр зэрэг зэрэг тоног төхөөрөмжийг нийлүүлэн хүлээлгэн өглөө.

3. Франц Улсын Мерсел хотын Анагаах Ухааны Их Сургуулийн Түлэнхийн нөхөн сэргээх мэс заслын багтай “ дахь жилдээ хамтран ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 06-р сард албан ёсны гэрээ хийн, нийт 66 үйлчлүүлэгчдэд үзлэг оношилгоо, 18 өвчтөнд хагалгаа хийж хамтран ажиллалаа.

4. Энэтхэг улсын БЛК нарийн мэргэжлийн эмнэлэг, Ховд аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний төвийн хооронд эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэхэд гарч буй хүндрэл болон дутагдалыг сайжруулах шаардагдах эмчилгээний тоног төхөөрөмжийн хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сурган хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурлаа. Ховд аймаг дахь БОЭТ болон БЛК нарийн мэргэжлийн эмнэлэг нь өөрсдийн мэдлэг, ур чадвар болон туршлагаа хуваалцах зорилгоор энэ удаад Энэтхэг улсын БЛК эмнэлгийн Хавдрын мэс заслын болон Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын эмч ДОКТОР ХИМАНШУ ШУКЛА, Элэг шилжүүлэн суулгах хэлтсийн Захирал & Ахлах Зөвлөх ДОКТОР (ПРОФ.) САНЖЭЙ НЕГИ нар 2018.10.22 ны өдөр үзлэг хавдрын чиглэлээр нийт 56 үйлчлүүлэгчид үзлэг оношлогоо хийн зөвөлгөө өгч ажиллалаа.

5. АНУ-ын Энх Тайвны Корпустай 1 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээ хийсний дагуу Сайн дурын ажилтан Аманда Гурлиэ 2017. 08 сараас эхлэн нэг жилийн хугацаатай ажиллалаа. Аманда нь 2017.09 сараас эхлэн англи хэлний сургалтыг Анхан шат, Дунд шат, Гүнзгий шат гэж 3н түвшинд хуваан 7 хоногт тус бүр 2 цагийн сургалт, мөн гэрээний хугацаанд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт зохион байгуулж хамтран ажиллахаас гадна эмчилгээний хоолны тасагтай хамтран “Хүүхдийн хоол тэжээлийн сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

6. Монгол улсын Засгийн газар, Белгийн засгийн газартай хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх төсөл” хэрэгжиж тоног төхөөрөмжүүд суурилагдаж эхлээд байна.

7. Ховд БОЭТ-д 2018.11.06 ны өдөр БНСУ-ын “КОЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын суурин төлөлөгч Жу Хэйн-Нан, сайн дурын хөтөлбөрийн зохицуулагч Кан Жи-Ён, Аюулгүй байдал, хариуцсан менежер Д. Лхагвадорж орчуулагч менежер Ц. Төмөрчулуун нар ажиллаж хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилт, хэрэглээний байдалд үнэлгээ өгч, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцаж ирэх онуудад тасралтгүй сайн дурын гишүүд ирүүлэн хамтран ажиллахаар ярилцлаа.

8. Солонгосын Soon Chun Huiyang их сургууль, Choo hospital, Central hospital ийн ерөнхийлөгч Cho Wan Tae, Олон улсын эрүүл мэндийн төвийн захирал Б. Эрдэнэбаяр нар тус төвтэй танилцан 2018 оны 11 сарын 28 өдөр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Уг гэрээгээр 2019 оноос эхлэн эмч мэргэжилтнүүдийг Солонгос улсад төрөлжсөн нарийн мэргэжилээр сургах, олон талт төслүүд дээр хамтран ажиллахаар тохирлоо.

9. Азийн хөгжлийн банк (АХБ)-ны Монгол дахь Суурин төлөөлөгч Ёланда Фернандез Ломмен дагалдах хүмүүсийн хамт 2018 оны 10-р сарын 16 ны өдөр Ховд аймгийн Бүсийн Оношлогоо Эмчилгээний төвд ажиллаж АХБ-ны санхүүжилтээр ЭМСХХ-5 төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт ба үр дүнгийн талаар уулзалт хийж газар дээр нь танилцлаа. 2016 онд Цусны салбар

банкинд Азийн хөгжлийн банкны ЭМСХХ-5 төслөөр нийт 565.826.821 төгрөгний 58 нэр төрлийн, 101 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн бүрэн шинэчлэл, цусны салбар банкны засварын ажил нийт 74.238.457 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн. 2017 онд Хог хаягдлын байр – 140.055.979 төгрөг, 2018 онд – Эмнэлгийн Хог хаягдлын тоног төхөөрөмж 266.002.000 төгрөг хөрөнгө оруулалт тус тус хийгдээд байна.

Уг төсөл хэрэгжсэнээр цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал бүрэн хангагдаж цус, цусан бүтээгдэхүүнийг 12 нэр төрлөөр хаягдалгүй бэлтгэн -80 0 С 2 жил хүртэлх хугацаагаар нөөцлөх, ховор бүлгийн цустай эх, өвчтөнг УБ тээвэрлэх шаардлагагүй өөрсдийн нөөцөөр эмчлэх боломж бүрдсэн. Мөн эмч мэргэжилтнүүдийг тасралтгүй багаар нь сургасан бэлтгэж өгсөн байна.

Мөн эмнэлгийн хог хаягдлын аюулгүй байдлыг бүрэн ханган хог ангилан ялгах, аюулгүй болгох зориулалт бүхий 500 литр багтаамжтай автоклав болон бутлагч машин, хог хаягдлын дагалдах хэрэгслээр бүрэн хангасан.

Харилцан туршлага солилцох аялал, гадаад сургалт

1. 2018-2020 АШУҮИС-ийн Сайбер Их сургуулийн зайн сургалтаар 6 их эмч оон улсын магистрантурт суралцаж байна.

2. ОХУд Дүрс оношилгооны эрхлэгч их эмч Түмэндэмбэрэл компьютер томографик, ЭХО-ны чиглэлээр 1 сарын сургалтанд 2017.11.05-12.05 сард амжилтай сайн суралцаж ирлээ.

3. Их эмч Д. Отгонбаяр Уранчимэг нар Энэтхэг улсад 5 хоногийн “Элэгний эмчилгээний орчинүеийн чиг хандлага” сургалтанд 2018.09 сард оролцлоо.

4 Эдийн засагч Г. Саруулзаяа АНУ-д, их эмч Б. Соёл-Эрдэнэ, биотехнологич О. Заяа нар Тайваньд магистр суралцаж байна.

5. их эмч Б. Амаржаргал, Ц. Нарангэрэл, Д. Бадамхорлоо нар Польш болон Турк улсад Олон улсын эмч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтанд 2018 оны 05 сард,

6. их эмч Д. Цэрэнбадам Солонгос улсад танилцах уулзалт сургалтанд хамрагдсан.

7. ӨМӨЗО Хөх хотын эмнэлэгүүдэд 2018.05.31-2018.06.10 өдрүүдэд тус төвийн 10 эмч мэргэжилтэн танилцах аялал хийлээ.

Тайлан бичсэн

Б. Алтанчимэг

/Сургалт, гадаад хамтын ажиллагааны албаны дарга/